



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/213

Улаанбаатар хот

Төсөл хэрэгжүүлэх хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Инновацийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.15, 7.1.16 дахь заалт, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалт, Засгийн газрын 2014 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан "Эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд гарааны компани байгуулах журам"-ын 1.6 дахь заалт, Онцгой байдлын ерөнхий газрын 2022 оны 2/677 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн дэргэдэх "Гарааны байгалийн эрдэст багсармал тэжээл" ХХК-ийн "Сорт сорил, тэжээлийн үйлдвэрлэлийн" инновацийн төсөл хэрэгжүүлэх хугацааг 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл 2 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Төслийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг, Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацийн хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Баттогтох/-т даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН



142210761